

“ҮНЭЛГЭЭ-МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХӨГЖИЖ БЭХЖИХЭД УЧИРЧ БУЙ СААД БЭРХШЭЭЛҮҮД”

**ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИУДЫГ ТӨЛӨӨЛЖ,
ЗОЛАЧ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Д.АЛТАНЦЭЦЭГ**

ӨӨДЛӨХ АЙЛЫН ҮГ НЬ НЭГ, ӨСӨХ МАЛЫН ЗҮС НЬ НЭГ, САНАА НЭГ БОЛ ЗАЯА НЭГ

- *Үнэлгээ бол мэргэжлийн үйлчилгээ, мэргэжлийн үйлчилгээ учраас мэргэжлийн удирдлагатай байдаг.*
- *Бидэнд нэгдмэл удирдлагатайгаар, нэг зүгт, нэг санаатайгаар хөгжиж улмаар бэхжих шаардлага тулгараад байна.*
- *Үнэлгээчид маань нэг үгтэй, нэг санаатай, нэг зүг рүү харж хөгжмөөр байна.*
- *Хамгийн гол саад бэрхшээл бол үнэлгээнээс өөр зүйлтэй зууралддаггүй, зөвхөн үнэлгээгээр мэргэшсэн хүмүүсээс бүрдсэн мэргэжлийн удирлага, удирдах зөвлөл хэрэгтэй байна.*
- *Зөв удирдаад аваад явбал зөв хөгжинө.*
- *Манай мэргэжлийн байгууллагын удирдах зөвлөлд маш ухаантай, мундаг боловсрол, аудитын туршлагатай, гайхалтай сайхан хүмүүс байгаа. Бид бүгдээрээ энэ мундаг чадалтай хүмүүсийг хүндэлдэг учраас 4 жилийн өмнө олонхийн саналаараа удирдах зөвлөлдөө сонгосон.*

Гэтэл манай салбар хөгжиж байна уу?

Хамт олон энэ талаар юу гэж бодож байгаа бол?

Миний харж байгаагаар бол бид зогсонги байдалд орсон, магадгүй зарим талаар
ухарсаар байгаа.

Яагаад? Ямар саад бэрхшээл байна? Ажил, мэргэжил нэгт нөхөд минь
хариулаарай.....???

Үнэлгээчид гэдэг нэг ижил мэргэжилтэй, амьдарлаа яг ижилхэн үнэлгээ хийж нэг л аргаар залгуулдаг хамт олны санаа нэг байвал үнэлгээний салбар хөгжинө, тэгэхгүйгээр өнөөдрийнх шиг аудитын ажлаа нэгдүгээр зэргийн үйлчилгээ болгочихоод хажуугаар нь туслах хоёрдугаар зэргийн ажлаар үнэлгээний үйлчилгээг тавьчихаад яваад байвал энэ салбарын нэр хүнд унасаар байх болно.

Саад бэрхшээл гэсэн болохоор мэдээж сөрөг л юм ярьж таарна, тийм болохоор та нар минь намайг уучлаарай.

Ер нь олон жилийн турш амьдарлын минь үндсэн арга болсоор ирсэн үнэлгээний ажил, энэ салбарынхаа өнөөгийн байгаа байдал, маргаашийн төлөвийн төлөө миний санаа сэтгэл их зовж байна, зөв сайхан хөгжиж дэвжээсэй гэж хүсэж байна. Хүссэнээр минь болохгүй байгаад эмзэглэж байна.

Энд сууж байгаа хүмүүс дотор миний хэлэх үнэн үгэнд дургүйцэх хүмүүс байгаа. Тэр хүмүүсээс би урьдчилан уучлалт гуйж байна.

Тэр хүмүүс бол аудиторууд байгаа. Та нар минь өөрсдийгөө зөвхөн үнэлгээ хийж амьдарлаа залгуулж байгаа хүмүүсийн оронд тавиад үзээрэй гэж хэлье, тэгвэл та бүхэн ойлгоноо.

За ингээд оршил, тайлбараа хийчихлээ, одоо нөгөө саад бэрхшээлүүдээ тоочье доо.

Мэдээж бүхэлдээ үнэлгээний мэргэжлийн үйл ажиллагааг өнөөдрийнх шиг биш, илүү эмх цэгцтэй, ёс зүйтэй, өндөр чанартай эрхлэн явуулахъя гэвэл маш олон саад бэрхшээл байгаа.

Энэ удаад надад зөвхөн 15 минут өгөгдсөн тул би хамгийн чухал, хамгийн гол 2 саад тотгорыг л би энд ярьж байгаа.

А. АУДИТЫН КОМПАНИУД ҮНЭЛГЭЭ ХИЙЖ БАЙГАА НЬ ҮНЭЛГЭЭНИЙ САЛБАРЫН ХӨГЖИЛД МАШ ИХ ХОР ХОХИРОЛ УЧРУУЛЖ БАЙНА.

Учир нь аудитын болон санхүүгийн зөвөлгөө өгдөг компаниуд үнэлгээний үйлчилгээний үндсэн хэрэглэгчдэд хуулийн дагуу хүрч өөрсдийнхөө үндсэн аудит, санхүүгийн зөвлөх үйлчилгээгээ үзүүлдэг. Эндээс үнэлгээний үндсэн хэрэглэгчид нь аудитын компаниар үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ хийлгэх ёстой гэж ярьж бичдэг болсон, тэгээд ч хийлгэдэг, үүнийг хэн ч хорьж хязгаарладаггүй. Үнэлгээний мэргэжлийн компаниуд байдаг гэдгийг том хэрэглэгчид бүр мартсан. Саяхан болсон татвар, аудитын хуулиудын нэмэлт өөрчлөлтийн хэлэлцүүлгээр бид бүгдээрээ харсан. Энэ тал дээр бүр замбараагаа алдсан. Том хэрэглэгчдэд хүрэх үнэлгээний компаниудын боломж бүрмөсөн хумигдсан. Тэгвэл үнэлгээний, мэргэшсэн нябогийн институтууд тусдаа байх ямар хэрэг байгаа юм бэ? Зааг байна уу?

Үнэлгээгээр дагнан ажилладаг, аудит хийдэггүй үнэлгээчид үндсэндээ зах зээлгүй, ажилгүй, санхүүгийн чадваргүй, мэргэжлийн хувьд өсөж сайжрах боломж муу байна.

Тийм үү, үгүй юу?.....

Яагаад?

Үнэлгээний ажлын ямар ямар зах зээл байна?



	Зах зээл	Ямар харилцаагаар зохицуулагдаж,энэ зах зээл дээр хэн ажиллаж байна	Хууль эрх зүйн шалгуур нөхцөл
	Шүүхийн шийдвэрийн	-Зоригоо -эрдэнэбаяр -эрдэнэбаатар	Үнэлгээчдийг ямар системээр сонгон гэрээ хийж байна?
	Зээлийн барьцааны	Банкууд өөрсдөө үнэлж байгаа нь зээлдэгчдийн эрх ашгийг ноцтой зөрчиж байна	Зээлдүүлэгчид эрх ашиг сонирхол гэж байгаа бол зээлдэгчийн эрх ашиг бас хангагдах ёстой учраас хараат бус хөндлөнгийн үнэлгээ байх ёстой байх
	Татварын зориулалттай /Үнэлгээний зах зээлийн дийлэнхи хэсэг нь ашиг сонирхолын зөрчилтэй хийгддэг/	Аудитын дүгнэлт гаргах, ихэнх томоохон компаниудын санхүүгийн удирдлагууд нь өөрсдөө аудиторууд, эсвэл ажил мэргэжил нэгтэй түнш, найз нөхдүүд, татварын болон санхүүгийн зөвлөхүүд байдаг тул энд маш их ашиг сонирхолын зөрчил байдаг хэдий ч энэ төрлийн үнэлгээний ажлуудын гүйцэтгэгчид нь аудитын л компаниуд байдаг.	Татварыг бага байлгах хамгийн оновчтой арга бол үндсэн хөрөнгийн үнэлгээний арга байдаг. Цаг үеэ олсон татварын зориулалттай үнэлгээ нь тухайн байгууллагын хувьд мэдээж маш чухал.таг.зор-тай үнэлгээний гол зорилго нь үндсэн хөрөнгийн үнэлгээг нэмэгдүүлж элэгдлийн шимтгэлийг өсгөх замаар төлөх татварын хэмжээг аль болох багасгах явдал гэдгийг бид мэднэ.
	Санхүүгийн тайлагналын зориулалттай МСО СТАНДАРТ 3 ОЦЕНКА В ЦЕЛЯХ ФИНАНСОВОЙ ОТЧЕТНОСТИ И СМЕЖНОЙ ДОКУМЕНТАЦИИ /ст1,2,3/	Аудиторууд энэ төрлийн үнэлгээг хийх нь зохимжгүй, гэтэл энэ зах зээл бараг бүхэлдээ тэдний хяналтанд байна.	ҮОУС.Стандарт 3 Санхүүгийн тайлагнал болон холбогдох баримт бичгүүдэд зориулагдсан үнэлгээний тайланг бусад баримт бичгүүдийн хамт аудиторууд хянадаг
	Бизнесийн үнэлгээ	СЗХ-ны зохицуулалтаар харин ч зөвхөн үнэлгээний компаниуд хийж байгаа.	СЗХ-ны зохицуулалтаар аудитын компани үнэлгээ хийхийг хориглох хэрэгтэй байна. Тэд аудитынхаа мэргэжлийн үйлчилгээгээр дагнан хөгжих нь илүү ашигтай
	Бусад үнэлгээнүүд	Бас л гол төлөв санхүүгийн зөвлөгөө өгдөг, аудит хийдэг компаниуд хоорондоо гүйлгэдэг	

ИЙМ УЧРААС:

- Аудитын компаниудад ажилладаг мэргэшсэн нягтлан бодогчид үнэлгээ хийх ёс зүйн болон эрх зүйн боломж нь эрхэлж буй ажил мэргэжил нь давхцаж, ашиг сонирхолын зөрчил нэлэнхүйдээ үүснэж байгаа. Бас дээрээс нь НӨТ-тэй холбоотой ашиг сонирхолын зөрчил ч байж болох талтай. Ямар ч гэсэн энд ямар нэгэн байдлаар ашиг сонирхолын зөрчил байдаг.
- Ийм байдал газар аваад байхад жинхэнэ үнэлгээний үйл ажиллагаа эрхэлдэг, үнэлгээний мэргэжлээрээ дагнасан, ямар ч сонирхолын зөрчил агуулаагүй үнэлгээчдэд зах зээл байхгүйн улмаас санхүүгийн хувьд бэхжиж чадахгүй, мэргэжлээрээ өсөж дэвжих боломж нь үүгээр хязгаарлагдмал байх жишээтэй. Үнэлгээчдийн амьдралд дэмжлэг үнэхээр шаардагдаж байгаа.
- Мэдээж үнэлгээний үйлчилгээний чанар нь анхаарлын төвд байх гол асуудал бас мөн. Гэхдээ үнэлгээчдийн бүтэц, тусгай зөвшөөрөл олгож буй байдлыг тухайн асуудлыг эрхэлсэн эрх бүхий этгээдүүд нь улс нийтийнхээ эрх ашгийг хүндлээд, сэтгэл гаргаад хүнэлэг, соёлтой байдлаар шийдчихвэл бусад нь үнэлгээчдийн өөрсдийнх нь хичээл зүтгэлээр болоод явчихмаар байгаа юм. Ингэж чадвал хөгжих дэвших ноён нуруутай болно.

Б. ДАРААГИЙН ГОЛ БЭРХШЭЭЛ БОЛ МЭРГЭЖЛИЙН ХҮМҮҮСЭЭР МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГАА УДИРДУУЛАХ ХЭРЭГТЭЙ БАЙНА.

- Хажуугийн /смежный/ гол ажил мэргэжил нь аудит хийдэг хүмүүс аудитынхаа хажуугаар үнэлгээний мэргэжлийн байгууллагыг удирдахад оролцвол мэдээж яавал аудиторуудад илүү ашигтай байх уу? гэж л бодож удирдлагад оролцно, ингэж ч байгаа, ийм ч учраас үнэлгээний салбар бие даасан мэргэжлийн байгууллагын хувьд зөв хөгжиж, бэхжиж чадахгүй ийм сул дорой байгаа юм. Дотоодын зөрчил их байна. Аудиторуудад давуу боломжууд их болсон учраас жинхэнэ үнэлгээний компаниудын зах зээлийг эзлэн авч, тэднийг санхүүгийн болон мэргэжлийн хувьд өсөж хөгжхөд маш их саад хохирол учруулж байгаа.
- Мэргэжлийн ТББ гэдэг бол идэвхитэй, чин сэтгэлтэй гишүүдийнхээ хүчийг бүрэн дайчлан ашиглаж байж л амжилттай хөгжих учиртай. Өөр ажил мэргэжилд гол анхаарлаа хандуулдаг хүмүүс ММҮИ- н хөгжилд зөвхөн саад л болно. Өнөөдөр манайх ийм л байна.

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА. ҮНЭЛГЭЭНИЙ САЛБАР ХӨГЖИЖ ДЭВЖИХ
БОЛТУГАЙ!

ТА БҮХЭНДЭЭ АМЖИЛТ ХҮСЬЕ!